ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2023 оны 10 сарын 31 өдөр Дугаар 128 Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтын 1-т заасан хуулийн этгээдийн "Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх" тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар, 2-оос 3-т заасан хуулийн этгээдийн "Арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх" болон "Радио давтамж, давтамжийн зурвас ашиглах" тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар, 4-т заасан хуулийн этгээдийн "Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх" тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар тус тус сунгасугай.
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тусгай зөвшөөрлийн хугацаа сунгагдсан хуулийн этгээдүүдтэй гэрээ байгуулж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА Г.ЧИНЗОРИГ

ГИШҮҮД Ч.ЗОЛБАЯР

Ө.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

Н.МАНДАХБААТАР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР

Харилцаа холбооны зохицуулах хорооны
2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн
128 тоот тогтоолын
хавсралт

Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгасан хуулийн этгээдийн
жагсаалт

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	Тусгай зөвшөөр-лийн дугаар	Хугацаа	Хамрах хүрээ, Үйлчилгээний хүртээмж
1	Эгон ХХК /Шоп монголия/	12900106	2023.10.25 2028.10.25	Монгол Улсын нутаг дэвсгэрт "Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх"
2	Шүхэр ТББ /Хамаг Монгол FM-95.1/	12800111	2023.10.01 2028.10.01	Улаанбаатар хотын "Арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх" болон "Радио давтамж, давтамжийн зурвас ашиглах"
		22800117	2023.06.24 2028.06.24	
3	Чугу ХХК /Vibe FM-105.5/	12800019 22800037	2024.01.01 2029.01.01	Улаанбаатар хотын "Арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх" болон "Радио давтамж, давтамжийн зурвас ашиглах"
4	Монгол экспресс ХХК	43300013	2023.06.22 2028.06.22	Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх

------ oOo --------